



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2025/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.gov.mn](#)

Улиастай сум

2025 он

Дарга,

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Uncraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Жалбаа

Утас: 89330330

Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.БОЛДБААТАР-Т

2025.01.27 № 28
Тайлантай -ны № -т

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдсан 20.5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар хурлын даргын дэргэд зөвлөх томилон ажиллуулсан зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулагдаж аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар шинээр сонгогдон ажиллаж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

0130-0175

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлднэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,571,071.55	25,572,943.00
33	АВЛАГА	21,128,571.55	20,587,043.00
335	Бусад авлага	21,128,571.55	20,587,043.00
3351	Байгууллагаас авах авлага	21,128,571.55	20,587,043.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,442,500.00	4,985,900.00
354	Хангамжийн материал	7,442,500.00	4,985,900.00
35410	Бичиг хэргийн материал	440,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	4,822,500.00	4,985,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,180,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	174,545,432.60	80,904,073.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	174,545,432.60	80,904,073.77
392	Биет хөрөнгө	174,545,432.60	80,904,073.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,000,000.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,656,250.41	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,000,000.00	74,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-24,666,666.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,942,515.00	68,164,326.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,459,044.71	-40,095,444.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,999,525.12	19,935,385.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,281,312.40	-16,433,526.32
393	Биет бус хөрөнгө	00.00	00.00
39301	Программ хангамж	480,000.00	480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,000.00	-480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	203,116,504.15	106,477,016.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	203,116,504.15	106,477,016.77
51	Засгийн газрын хувь оролцоо	203,116,504.15	106,477,016.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	98,985,450.00	98,985,450.00
51101	Өмч: - төрийн	98,985,450.00	98,985,450.00
512	Хуримтлагдсан үр дүн	95,760,542.51	7,270,863.77
51210	Өмнөх үеийн үр дүн	95,760,542.51	103,910,351.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-96,639,487.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,370,511.64	220,703.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	203,116,504.15	106,477,016.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,072,187,700.00	1,341,647,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,072,187,700.00	1,341,647,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,021,187,700.00	1,300,550,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,021,187,700.00	1,300,550,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,000,000.00	41,097,500.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,000,000.00	41,097,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,055,022,592.54	1,391,162,187.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,055,022,592.54	1,391,162,187.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,027,592,109.17	1,326,499,093.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,396,428.82	490,755,483.80
210101	Үндсэн цалин	193,170,408.01	271,344,343.28
210102	Нэмэгдэл	98,970,919.96	160,506,592.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,163,000.00	43,828,000.00
210104	Урамшуулал	10,229,062.15	15,076,548.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,863,038.70	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,008,135.65	61,519,000.04
210201	Тэтгэврийн даатгал	29,173,202.14	41,838,867.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,432,141.45	4,969,533.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,692,913.10	2,451,766.62
210204	Ажилгүйдлийн даатгал	609,989.06	2,451,766.62
210205	Эрүүл мэндийн даатгал	6,099,889.90	9,807,066.37
2104	Хангамж, бараа материалын зардал	64,153,487.60	81,249,338.18
210401	Бичиг хэрэг	3,333,890.00	3,714,450.00
210402	Тээвэр, шатахуун	50,757,050.00	69,464,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,447.60	4,385,668.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,769,100.00	3,685,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,500,200.00	27,784,500.00
210604	Урсгал засвар	38,500,200.00	27,784,500.00
2107	Томилолт, зочны зардал	16,987,100.00	20,025,400.00
210702	Дотоод албан томилолт	16,987,100.00	20,025,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	408,676,694.00	469,365,372.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,946,750.00	465,844,440.50

210803	Даатгалын үйлчилгээ	1,238,600.00	978,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,664.00	90,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,106,680.00	2,430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,870,063.10	175,799,998.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,227,440.00	91,792,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,677,410.00	30,011,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,965,213.10	53,454,920.27
210904	Найдваргүй авлагын алдагдал	00.00	541,528.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,430,483.37	64,663,094.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	22,571,483.37	16,979,633.98
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	22,571,483.37	16,979,633.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,859,000.00	47,683,460.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,859,000.00	5,742,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	41,941,460.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>17,165,107.46</u>	<u>-49,514,487.82</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	47,124,999.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	47,124,999.56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-47,124,999.56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>17,165,107.46</u>	<u>-96,639,487.38</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,072,187,700.00</u>	<u>1,341,647,700.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,072,187,700.00</u>	<u>1,341,647,700.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,021,187,700.00	1,300,550,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,021,187,700.00	1,300,550,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,000,000.00	41,097,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө түүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,000,000.00	41,097,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,037,356,942.00</u>	<u>1,334,709,139.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,037,356,942.00</u>	<u>1,334,709,139.00</u>

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,926,458.63	1,270,046,044.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,396,428.82	490,755,483.84
210101	Үндсэн цалин	195,853,426.37	272,523,061.99
210102	Нэмэгдэл	98,970,920.00	159,357,328.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,163,000.00	43,798,545.45
210104	Урамшуулал	10,229,062.15	15,076,548.00
210105	Гэрээт ажлын хөлс	14,180,020.30	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,008,135.65	61,519,000.00
210201	Тэтгэврийн даатгал	29,173,202.14	41,838,867.19
210202	Тэтгэмжийн даатгал	3,432,141.45	4,969,533.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,692,913.10	2,451,766.62
210204	Ажилгүйдлийн даатгал	609,989.06	2,451,766.62
210205	Эрүүл мэндийн даатгал	6,099,889.90	9,807,066.37
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,654,637.60	77,181,338.18
210401	Бичиг хэрэг	3,333,890.00	3,274,450.00
210402	Тээвэр, шатахуун	43,464,200.00	65,464,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,293,447.60	4,385,668.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,563,100.00	4,057,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,130,200.00	25,604,500.00
210604	Урсгал засвар	40,130,200.00	25,604,500.00
2107	Томилолт, зочны зардал	16,987,100.00	20,217,400.00
210702	Дотоод албан томилолт	16,987,100.00	20,217,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	416,176,206.56	473,173,372.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,446,262.56	469,652,440.50
210803	Даатгалын үйлчилгээ	1,238,600.00	978,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,664.00	90,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,106,680.00	2,430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,573,750.00	121,594,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,574,340.00	91,594,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,999,410.00	30,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,430,483.37	64,663,094.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	22,571,483.37	16,979,633.98
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	22,571,483.37	16,979,633.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,859,000.00	47,683,460.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,859,000.00	5,742,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	41,941,460.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,830,758.00	6,938,561.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,830,758.00	6,938,561.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,830,758.00	6,938,561.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,830,758.00	6,938,561.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,830,758.00	6,938,561.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-34,830,758.00</u>	<u>-6,938,561.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,419,234.64	-33,818,159.95	73,586,524.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	48,720.00	48,720.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985,450.00	8,419,234.64	-33,769,439.95	73,635,244.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,077,639.87	29,077,639.87
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,370,511.64	95,760,542.51	203,116,504.15
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	8,370,511.64	95,760,542.51	203,116,504.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,149,808.64	8,149,808.64
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	98,985,450.00	8,370,511.64	103,910,351.15	211,266,312.79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,149,808.64	00.00	-8,149,808.64
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-96,639,487.38	-96,639,487.38
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,985,450.00	220,703.00	7,270,863.77	106,477,016.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,300,351,800.00	1,283,571,416.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,351,800.00	1,283,571,416.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,351,800.00	1,283,571,416.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,151,600.00	490,755,483.84
210101	Үндсэн цалин	259,836,800.00	272,523,061.99
210102	Нэмэгдэл	183,437,400.00	159,357,328.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,857,600.00	43,798,545.45
210104	Урамшуулал	33,019,800.00	15,076,548.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,519,200.00	61,519,000.00
210201	Тэтгэврийн даатгал	41,832,900.00	41,838,867.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,921,500.00	4,969,533.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,461,000.00	2,451,766.62
210204	Ажилгүйдлийн даатгал	2,460,800.00	2,451,766.62
210205	Эрүүл мэндийн даатгал	9,843,000.00	9,807,066.37
2104	Хангамж, бараа материалын зардал	78,660,200.00	78,660,199.18
210401	Бичиг хэрэг	3,275,000.00	3,274,450.00
210402	Тээвэр, шатахуун	63,464,200.00	63,464,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,000.00	4,385,668.18
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,321,000.00	7,535,881.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,408,900.00	21,507,000.00
210604	Урсгал засвар	22,408,900.00	21,507,000.00
2107	Томилолт, зочны зардал	20,224,000.00	20,217,400.00
210702	Дотоод албан томилолт	20,224,000.00	20,217,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	478,459,800.00	476,633,072.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	473,560,800.00	473,112,140.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,641,000.00	978,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	90,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,430,000.00	2,430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86658100.00	86595800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,658,100.00	56,595,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,000,000.00	30,000,000.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60270000.00	47683460.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,270,000.00	47,683,460.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,742,000.00	5,742,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,528,000.00	41,941,460.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,300,351,800.00	1,300,550,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,300,351,800.00	1,300,550,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,300,351,800.00	1,300,550,200.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	14.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	02.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,096,650.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,097,500.00
210604	Урсгал засвар	4,097,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,999,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,999,150.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,097,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,097,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,097,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага мөн юм.

Тус байгууллага нь 2024 онд 4 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 92.4 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 96.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	21,128.6	20,587.0	-541.6
Бараа материал	7,442.5	4,985.9	-2,456.6
Үндсэн хөрөнгө	174,545.4	80,904.1	-93,641.3
Нийт хөрөнгө	203,116.5	106,477.0	-96,639.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	203,116.5	106,477.0	-96,639.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	203,116.5	106,477.0	-96,639.5

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх аудитаар олон жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийн хүрээнд данс бүртгэлээс найдваргүй авлагыг хассантай холбоотой байна. 2024 оны жилийн эцсийн үлдэгдэл 20.5 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/07 тоот захирамжаар дансанд бүртгэлтэй 65.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй орон сууцыг дуудлага худалдаагаар борлуулсан, 2024 оны А/45 тоот захирамжаар 11.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталсан зэрэгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үндсэн үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгаа, зөвлөл хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс, биеийн тамир уралдаан тэмцээн, сургалт семинар, ажил олгогчоос олох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гэсэн 6 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,287.9 сая төгрөгийг баталжээ. Төсөвт тодотгол хийж 12.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,300.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 16.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, гүйцэтгэл 98.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	730,706.7	714,438.1	16,268.6	97.8
2	Мэдээлэл сурталчилгаа	5,258.1	4,810.0	448.1	91.5
3	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	237,415.0	237,414.2	0.8	100
4	Биеийн тамир уралдаан тэмцээн	22,000.0	21,937.7	62.3	99.7
5	Сургалт, семинар	26,400.0	26,400.0	0	100
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	47,683.8	47,683.5	0.5	100
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	230,888.2	230,888.0	0	100
	ДҮН	1,300,351.8	1,283,571.5	16,780.3.0	98.7

/мянган төгрөгөөр/

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 41.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-аас малын сэг зэм устгах ажилд хяналт хийхэд зориулан олгосон 4.1 сая төгрөг
- Аймгийн техник хяналтын зардлаас улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудад хяналт тавих 2.0 сая төгрөг
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны зардалд дэмжлэг үзүүлэх 35.0 сая төгрөг зэрэг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 2/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 1,055.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 1,391.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөх авч ажиллуулсан байна. Уг зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад алдаа зөрчил илрээгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхээр төлөвлөсөн ч ажлын ачааллын улмаас хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар 242.9 сая төгрөгийн зөрчилд 8 заалт зөвлөмж өгч, 7.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,380.0	1	7,380.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж	8	242,917.5	7	241,321.5	99.3
Нийт дүн	9	250,297.5	8	248,701.5	99.4

Шийдвэрийн биелэлтийг FAS системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна.

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн зөрчил илэрсний 1.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалд иргэнийг томилон ажиллуулсан 1.6 сая төгрөгийн зөрчил байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой

1.1 Илрүүлэлт: Батлагдсан төсвөөс шинэ жилийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан 3.9 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу гарган зөвлөмж хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан	1	16,978.8			1	16,978.8	1	16,978.8				
ДҮН	1	16,978.8			1	16,978.8	1	16,978.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвөөс шинэ жилийн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан	1	3,900.0					1	3,900.0				
ДҮН	1	3,900.0					1	3,900.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалд иргэнийг томилон ажиллуулсан	1	1,602.8	1	1,602.8			
Дүн	1	1,602.8	1	1,602.8			
Нийт дүн	1	1,602.8	1	1,602.8			

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

Б.ЖАЛБАА



2025.01.27

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2025.01.27

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

2025.01.27